

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/71/-НА-СТА-ТШЗ
ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

<u>1. Аудитын санал дүгнэлт</u>	Error! Bookmark not defined.
<u>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u>	4-8
<u>3. Аудитын тайлан</u>	9
<u>3.1 Ерөнхий зүйл</u>	9
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u>	9
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u>	10
<u>3.4 Материаллаг байдал</u>	10
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u>	11
<u>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u>	12
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u>	12
<u>3.8 Аудитын гол асуудал</u>	13
<u>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u>	13
<u>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u>	13
<u>3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал</u>	14
<u>4. Аудитын илрүүлэлт</u>	14
<u>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</u>	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/104
танай _____ -ныг № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.НАРАНТУНГАЛАГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020344

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,449,760.00	84,439,795.00
33	АВЛАГА	3,781,955.00	16,794,140.00
335	Бусад авлага	3,781,955.00	16,794,140.00
3351	Байгууллагаас авах авлага	3,781,955.00	16,794,140.00
35	БАРАА МАТЕРИАЛ	43,667,805.00	67,645,655.00
354	Хангамжийн материал	43,667,805.00	67,645,655.00
35410	Бичиг хэргийн материал	400,000.00	400,000.00
35420	Аж ахуйн материал	875,910.00	18,973,260.00
35470	Бусад хангамжийн материал	42,391,895.00	48,272,395.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,661,647,860.52	3,864,130,723.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,661,647,860.52	3,864,130,723.56
392	Биет хөрөнгө	2,929,968,060.52	3,132,450,923.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,277,530,232.72	2,390,431,805.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-401,116,425.51	-522,560,209.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	569,901,320.00	656,201,320.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-224,152,652.63	-277,768,557.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	376,491,518.10	443,795,244.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-202,711,045.42	-237,373,586.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	132,600,046.00	132,600,046.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-73,977,874.02	-84,670,681.02
39209	Зам, гүүрийн байгууламж	94,472,056.00	94,472,056.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-15,754,413.00	-24,431,591.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	695,343,824.40	929,236,924.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-298,658,526.12	-367,481,847.36
393	Биет бус хөрөнгө	731,679,800.00	731,679,800.00
39303	Бусад биет бус хөрөнгө	731,679,800.00	731,679,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,709,097,620.52	3,948,570,518.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,709,097,620.52	3,948,570,518.56
51	Засгийн газрын хувь оролцоо	3,709,097,620.52	3,948,570,518.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,237,518,913.32	2,237,518,913.32
51101	Өмч: - төрийн	1,505,839,113.32	1,505,839,113.32
51105	Нэмж төлөгдсөн капитал	731,679,800.00	731,679,800.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,064,414,509.80	1,303,951,585.84
51210	Өмнөх үеийн үр дүн	1,064,414,509.80	1,064,478,687.80
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	239,472,898.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	407,164,197.40	407,100,019.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,709,097,620.52	3,948,570,518.56

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	715,702,391.90	1,143,693,542.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,904,406.00	561,391,423.00
120	Нийтлэг татварын бус орлого	195,904,406.00	561,391,423.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,904,406.00	561,391,423.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	105,600,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	90,304,406.00	561,386,423.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	77,755,706.00	516,138,573.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	12,548,700.00	45,247,850.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	519,797,985.90	582,302,119.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,369,085.90	56,506,419.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,518,105.00	26,380,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,556,980.90	9,627,011.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	294,000.00	10,299,408.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	454,428,900.00	525,795,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	454,428,900.00	525,795,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	886,641,001.78	905,348,473.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	865,393,882.78	905,068,473.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	812,901,835.05	881,239,274.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,088,305.05	269,270,073.43
210101	Үндсэн цалин	181,990,735.22	191,053,124.75
210102	Нэмэгдэл	51,594,969.83	33,170,975.83
210105	Гэрээт ажлын хөлс	38,502,600.00	45,045,972.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,557,883.22	36,222,967.68
210201	Тэтгэврийн даатгал	34,557,883.22	36,222,967.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,410,064.00	51,531,884.00
210301	Гэрэл, цахилгаан	13,120,502.00	11,323,998.00
210302	Тулш, халаалт	34,289,562.00	40,207,886.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,060,378.00	47,475,840.00
210401	Бичиг хэрэг	5,450,900.00	2,527,500.00
210402	Тээвэр, шатахуун	25,607,950.00	35,235,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,708,000.00	4,217,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,577,700.00	5,495,800.00
210408	Бараа материал акталсны зардал	7,715,828.00	00.00
2105	Нормативт зардал	2,500,000.00	12,542,655.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	11,392,000.00
210502	Хоол, хунс	2,500,000.00	650,655.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,245,000.00	14,928,000.00
210604	Урсгал засвар	1,245,000.00	14,928,000.00
2107	Томиллолт, зочны зардал	4,022,300.00	5,613,400.00
210702	Дотоод албан томиллолт	4,022,300.00	5,613,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,899,451.00	6,759,161.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,443,151.00	5,302,861.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,096,300.00	1,096,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	387,118,453.78	436,895,292.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,975,531.70	123,109,583.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	130,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	306,142,922.08	313,655,709.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,492,047.73	23,829,199.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,182,100.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,182,100.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,309,947.73	23,829,199.89
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,247,119.00	280,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,247,119.00	280,000.00
221001	Их засвар	18,247,119.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	3,000,000.00	280,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-170,938,609.88	238,345,068.04
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	10,930,200.90	18,786,330.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	10,930,200.90	18,786,330.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	17,658,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	17,658,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	10,930,200.90	1,127,830.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-160,008,408.98	239,472,898.04

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,237,518,913.32	407,164,197.40	1,224,422,918.78	00.00	3,869,106,029.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,237,518,913.32	407,164,197.40	1,224,422,918.78	00.00	3,869,106,029.50
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-160,008,408.98	00.00	-160,008,408.98
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,237,518,913.32	407,164,197.40	1,064,414,509.80	00.00	3,709,097,620.52
D01	2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,237,518,913.32	407,164,197.40	1,064,414,509.80	00.00	3,709,097,620.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	64,178.00	00.00	64,178.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,237,518,913.32	407,164,197.40	1,064,478,687.80	00.00	3,709,161,798.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-64,178.00	00.00	00.00	-64,178.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	239,472,898.04	00.00	239,472,898.04
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,237,518,913.32	407,100,019.40	1,303,951,585.84	00.00	3,948,570,518.56

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	625,555,485.90	597,078,574.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,600,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	105,600,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,600,000.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	105,600,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	519,955,485.90	597,078,574.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,526,585.90	71,282,874.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,518,105.00	30,004,455.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрсөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрсөнгө	00.00	10,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрсөнгө	23,556,980.90	9,627,011.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	451,500.00	21,451,408.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	454,428,900.00	525,795,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	454,428,900.00	525,795,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	531,755,485.90	596,518,574.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,755,485.90	596,518,574.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,481,483.17	555,895,234.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,088,305.01	269,270,073.43
210101	Үндсэн цалин	181,990,735.18	191,053,124.75
210102	Нэмэгдэл	51,594,969.83	33,170,975.83
210105	Гэрээт ажлын хөлс	38,502,600.00	45,045,972.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,557,883.26	36,222,967.68
210201	Тэтгэврийн даатгал	31,455,348.43	25,237,835.84
210202	Тэтгэмжийн даатгал	785,083.71	2,812,432.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	617,986.96	2,179,386.42
210204	Ажилгүйдлийн даатгал	154,496.75	544,846.57
210205	Эрүүл мэндийн даатгал	1,544,967.41	5,448,465.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,410,064.00	51,531,884.00
210301	Гэрэл, цахилгаан	13,120,502.00	11,323,998.00
210302	Түлш, халаалт	31,289,562.00	40,207,886.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,215,850.00	30,795,250.00
210401	Бичиг хэрэг	5,850,900.00	2,597,500.00
210402	Тээвэр, шатахуун	17,607,950.00	18,309,950.00
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	1,708,000.00	4,217,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	175,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,000.00	5,495,800.00
2105	Нормативт зардал	2,500,000.00	12,542,655.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	11,392,000.00
210502	Хоол, хунс	2,500,000.00	650,655.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,245,000.00	15,013,000.00
210604	Урсгал засвар	1,245,000.00	15,013,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,022,300.00	5,613,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,022,300.00	5,613,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,399,451.00	2,371,661.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,943,151.00	915,361.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,096,300.00	1,096,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,042,629.90	132,534,343.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,042,629.90	132,404,343.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	130,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,274,002.73	40,623,339.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,182,100.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,182,100.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,091,902.73	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,091,902.73	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	40,623,339.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	40,623,339.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	93,800,000.00	560,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	93,800,000.00	560,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	93,800,000.00	560,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	93,800,000.00	560,000.00
221001	Их засвар	18,247,119.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	3,000,000.00	560,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	72,552,881.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-93,800,000.00	-560,000.00

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	560,028,900.00	546,718,952.27	525,795,700.00	501,966,500.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	560,028,900.00	546,718,952.27	525,795,700.00	501,966,500.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	431,246,800.00	417,936,852.27	525,795,700.00	501,966,500.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,090,800.00	272,088,305.01	278,690,800.00	269,270,073.43
210101	Үндсэн цалин	181,256,100.00	181,990,735.18	181,256,100.00	191,053,124.75
210102	Нэмэгдэл	52,332,100.00	51,594,969.83	52,332,100.00	33,170,975.83
210105	Гэрээт ажлын хөлс	38,502,600.00	38,502,600.00	45,102,600.00	45,045,972.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,732,200.00	34,557,883.26	37,623,200.00	36,222,967.68
210201	Тэтгэврийн даатгал	25,848,600.00	31,455,348.43	26,475,600.00	25,237,835.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,720,900.00	785,083.71	2,786,900.00	2,812,432.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,176,700.00	617,986.96	2,229,500.00	2,179,386.42
210204	Ажилгүйдлийн даатгал	544,200.00	154,496.75	557,400.00	544,846.57
210205	Эрүүл мэндийн даатгал	5,441,800.00	1,544,967.41	5,573,800.00	5,448,465.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,279,900.00	44,410,064.00	54,279,900.00	51,531,884.00
210301	Гэрэл, цахилгаан	6,161,500.00	13,120,502.00	6,161,500.00	11,323,998.00
210302	Түлш халаалт	40,618,400.00	31,289,562.00	43,618,400.00	40,207,886.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	00.00	4,500,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,973,200.00	21,973,200.00	20,552,800.00	20,552,800.00
210401	Бичиг хэрэг	3,850,900.00	3,850,900.00	2,552,500.00	2,377,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,414,300.00	16,414,300.00	13,783,300.00	13,783,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,708,000.00	1,708,000.00	4,217,000.00	4,217,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	00.00	175,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,613,400.00	4,022,300.00	5,613,400.00	5,613,400.00
210702	Дотоод албан томилолт	5,613,400.00	4,022,300.00	5,613,400.00	5,613,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,557,300.00	12,885,100.00	1,456,300.00	1,456,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,101,000.00	11,428,800.00	00.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00	360,000.00	360,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,096,300.00	1,096,300.00	1,096,300.00	1,096,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,000,000.00	27,000,000.00	126,079,300.00	115,819,075.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,000,000.00	27,000,000.00	126,079,300.00	115,819,075.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,182,100.00	39,182,100.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,182,100.00	39,182,100.00	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,182,100.00	38,182,100.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,600,000.00	89,600,000.00	00.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	89,600,000.00	89,600,000.00	00.00	00.00
221001	Их засвар	80,400,000.00	80,400,000.00	00.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	9,200,000.00	9,200,000.00	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	560,028,900.00	560,028,900.00	525,795,700.00	525,795,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	454,428,900.00	454,428,900.00	525,795,700.00	525,795,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	454,428,900.00	454,428,900.00	525,795,700.00	525,795,700.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	105,600,000.00	105,600,000.00	00.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	105,600,000.00	105,600,000.00	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29	29	29
620001	Удирдах ажилтан	07	07	07	07
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	14	14
620003	Үйлчлэх ажилтан	03	03	03	03
620004	Гэрээт ажилтан	05	05	05	05

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,744,630.90	53,928,734.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,744,630.90	53,928,734.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,744,630.90	53,928,734.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,442,650.00	10,242,450.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	220,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,193,650.00	4,526,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,249,000.00	5,495,800.00
2105	Нормативт зардал	2,500,000.00	12,542,655.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	11,392,000.00
210502	Хоол, хунс	2,500,000.00	650,655.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	245,000.00	13,513,000.00
210604	Урсгал засвар	245,000.00	13,513,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,514,351.00	915,361.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,514,351.00	915,361.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,042,629.90	16,715,268.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,042,629.90	16,585,268.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	130,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	560,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	560,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	560,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,526,585.90	71,282,874.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,526,585.90	71,282,874.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,518,105.00	30,004,455.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,556,980.90	9,627,011.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	451,500.00	21,451,408.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хуулийг чандлан биелүүлж, иргэддээ төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд оршино гэсэн зорилготой, орон нутгийнхаа хөгжлийн манлайлагч байж, мэдлэг, чадвар, ёс зүйд суурилсан төрийн захиргааны байгууллага юм.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын баг Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг мөрддөг байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас Заамар сумын "Заамар нутгийн хөгжлийг дэмжих сан"-ийн 2018-2021 оны эхний 9 сарын санхүүгийн үйл ажиллагаанд Төв аймгийн Засаг дарга бөгөөд Дотоод аудитын хорооны даргын баталсан 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 33/36 тоот удирдамжийн дагуу санхүүгийн хяналт шалгалт хийгдэж, шалгалтаар 96,794.5 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг бүртгэлд тусгаагүй гэсэн 2 албан шаардлага өгөгдсөн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зарлагын 886,641.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,299.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,974.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 13,580.2 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 280.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг түвшинг дахин тооцох шаардлагагүй гэж үзэв.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт зарлага 886,641.0 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны зарлага 905,348.5 мянган төгрөг, 18,707.5 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Заамар сумын Засаг даргын Тамгын газарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 525,795.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 561,386.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 56,506.4 мянган төгрөг нийт 1,143,688.5 мянган төгрөг өмнөх оноос 427,991.2 мянган төгрөгөөр буюу 59.8 хувиар нэмэгдсэн байна.

Зардал :

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 905,348.5 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 596,518.5 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 501,966.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100141355001 тоот дансанд 2021 онд 525,795.7 мянган төгрөгийн орлого, 525,795.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 100141355401 тоот дансанд 71,282.9 мянган төгрөгийн орлого, 71,282.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган.төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	3,782.0	16,794.1	-13,012.1
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	43,667.8	67,645.7	-23,977.9
Үндсэн хөрөнгө	3,661,647.8	3,864,130.7	-202,482.9
Нийт хөрөнгө	3,709,097.6	3,948,570.5	-239,472.9
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,709,097.6	3,948,570.5	-239,472.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,709,097.6	3,948,570.5	-239,472.9

Авлага дансны оны эхний үлдэгдэл 3,782.0 мянган төгрөг барагдуулж, оны эцэст нэмэлт санхүүжилтын татан төвлөрүүлсэн үлдэгдлийг 16,794.1 мянган төгрөгийг авлагаар тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 67,645.7 мянган төгрөг болж 23,977.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хандиваар ирсэн бараа материалаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,864,130.7 мянган төгрөг болж 239,472.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй хүлээн авсан 516,138.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж акталж устгасан 15,740.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,948,570.5 мянган төгрөг болж 232,472.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 444,556.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 444,556.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 14,840.3 мянган төгрөгөөр бууруулж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 419,716.4 мянган төгрөгөөр ирүүлсэн санал дээр сумын шилжих үлдэгдлээс 10,000.0 мянган төгрөг нэмж орон нутгийн төсвөөс 429,716.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр Заамар сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан байна.

Тус байгууллагын төсвийг Заамар сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 525,795.7 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 525,795.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 525,795.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 525,795.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 501,966.5 мянган төгрөгийг зарцуулж, 23,829.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 501,966.5 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь 23,829.2 мянган төгрөг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хандиваар 30,004.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10,200.0 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 9,627.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын

үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 24,451.4 мянган төгрөг нийт 71,282.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар хангамж бараа материалын зардалд 10,242.4 мянган төгрөг, нормативт зардалд 12,542.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 13,513.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 915.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 16,715.3 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 560.0 мянган төгрөг нийт 54,488.7 мянган төгрөг зарцуулж, 16,794.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага 2021 онд Заамар ургац ХХК-иас 13,096.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Заамар нутгийн хөгжлийг дэмжих сангаас 6,188.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 54,371.4 мянган төгрөгийн барилга байгууламж, 80,392.0 мянган төгрөгийн мал угаах ванн, 10,940.0 мянган төгрөгийн худгийн цахим төхөөрөмж, 140,000.0 мянган төгрөгийн цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа, 17,700.0 мянган төгрөгийн цагдаагийн авто машин, 50,000.0 мянган төгрөгийн Хайлааст багийн Ахмадын байр, Уулс Заамар ХХК 30,000.0 мянган төгрөгийн трактор, Илтгоулд ХХК 38,600.0 мянган төгрөгийн трактор, иргэнээс 6,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Эм Жи Жи Си ХХК 40,000.0 мянган төгрөгийн пресс өвс боогч зэрэг нийт 487,288.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч тайлагнасан байна.

Тус байгууллага 2021 онд Заамар нутгийн хөгжлийг дэмжих сангаас 8,530.2 мянган төгрөгийн бохирын шугам, 13,000.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай, Орон нутгийн хөгжлийн сангаас 7,320.0 мянган төгрөгийн гэрэлтүүлэг нийт 28,850.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч сайжруулалтаар бүртгэсэн байна.

Тус байгууллага тайлант онд 2021 онд 12,589.0 мянган төгрөгийг шүлхий болон ковидын зардалд зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Заамар гоулд ХХК-иас 6,500.0 мянган төгрөг, Илтгоулд ХХК-иас 6,500.0 мянган төгрөг, Гурван тамга ХХК-иас 7,000.0 мянган төгрөг, Заамар Өгөөмөр нөхөрлөлөөс 1,500.0 мянган төгрөг, иргэдээс 4,610.0 мянган төгрөг, Шижир алт цэцэрлэгээс 270.0 мянган төгрөг, Тосон овоот хайрхан ХХК-иас 3,624.4 мянган төгрөг нийт 30,004.4 мянган төгрөгийг коронавируст халдвар цар тахалд хандивласныг нэмэлт санхүүжилтийн дансанд тайлагнасан байна.

Тус байгууллага нэмэлт санхүүжилтийн дансанд орсон хандивын мөнгийг зарцуулахаар Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 5-ны өдрийн 2/27, 2021 оны 02 дугаар сарын 6-ны 2/35, 2021 оны 02 дугаар сарын 17-ны 2/30, 2021 оны 4 дүгээр сарын 26-ны 2/139 албан тоотуудыг Төв аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Сумын онцгой комиссын шатахуунд 21,246.1 мянган төгрөг, бусад зардалд 25,200.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 23, зарлагын 12 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 13 гүйлгээ байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага тайлант онд Коронавируст халдвар цар тахалтай холбогдуулан аж ахуй нэгж байгууллага, иргэнээс өгсөн 30,004.4 мянган төгрөгийн хандивын мөнгийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орноос өгч байгаа хандивыг Улсын онцгой комисс болон холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж, зарцуулалтыг олон нийтэд ил тод байлгаж, нэн шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд авч тайлагнасан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжтой холбоотой, орон нутгийн төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой 4 зөвлөмж, хууль тогтоомжтой холбоотой 2 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 2/201 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 82,224.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40,623.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 35,748.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 653.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.2.1 Залруулсан алдаа

Тус байгууллага тайлант оны мөнгөн гүйлгээний тайланд 40,623.3 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2.2 Төлбөрийн акт

Тус байгууллага тайлант онд Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн Б/28 тоот тушаал, 2021 оны 11 дүгээр сарын 22-ны Б/29 тоот тушаал, сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны Б/30 тоот захирамжаар төрийн албан хаагчдын үндсэн цалинг 0.5-1.5 дахин нэмэгдүүлэн 5,200.0 мянган төгрөгийн шагналт цалин олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.3-д “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

4.2.3 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 33,228.0 мянган төгрөгийн 11 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.6 дах заалтыг зөрчин Худалдааны 100 жилийн ойн арга хэмжээ тэмдэглэж медаль, энгэрийн тэмдгийн төлбөрт 2,520.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дах заалтыг зөрчин сургалт, семинар, зөвлөгөөний томилолтын зардалд 653.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Засаг даргын Тамгын газар	4	82,224.3	1	40,623.3	1	5,200.0	2	35,748.0	1	653.0

